



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/511

Есөнбулаг

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 33 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилтыг танилцуулах, 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрт иргэдийн санал санаачлагыг сонсож тусгах, малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх арга хэмжээний хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд Тонхил, Дарив, Тайшир, Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Дэлгэр, Бигэр сумдын 35 багт "Малчдад төрийн үйлчилгээ үзүүлэх" ажлыг зохион байгуулахад 17,000,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 17,000,000 (арван долоон сая) төгрөгийн зардлыг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

